

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН АЛБА**



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**Аудитын нэр: СҮХБААТАР СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аудитад хамрагдсан жил: 2024 эхний 9 сар

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “СҮХБААТАР СУМЫН ТТЗ”

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: “СҮХБААТАР СУМЫН ТТЗ”

АУДИТЫН ТӨРӨЛ: ДОТООД АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.10.21-2024.11.28

АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2024

1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 10 дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2024 оны 3 дугаар улирлын үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

Сүхбаатар сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна. Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад

Тайланг бэлтгэсэн:

**Дотоод аудитын нэгжийн
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Засаг
даргын дэргэдэх
Санхүүгийн хяналт,
дотоод аудитын албаны
дарга, СХШУАБ
Т.Одсүрэн

**Аудитын багийн
гишүүн:**

Дотоод аудитор
Г.Дорждэрэм,

Огноо:2024 оны 11 дүгээр
сарын 20 өдөр

Сүхбаатар сумын 2
дугаар баг.
Нутгийн удирдлагын II
байр

sankhuu_audit_se@yahoo.com

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,

- 2.1.Аудитын зорилго
- 2.2 Аудитын цар хүрээ
- 2.3.Аудитын арга аргачлал, хязгаарлалт

3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

- 3.1 Засаглалын талаар
- 3.2 Эрсдэлийн удирдлагын талаар
- 3.3 Дотоод хяналтын талаар

4.АУДИТЫН ҮР ДҮН

- 4.1 Илэрсэн асуудлууд

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,

- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2024 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- *Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэх;*
- *Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.*
- *Төсвийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт, хуваарилалт, үр дүн*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт үйл ажиллагааны үр дүн*
- *Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүн*

- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт
- Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх;
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын үр нөлөө
- Төрийн аудитын байгууллагаас 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам
- Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам
- СТОУС, НББОУС болон бусад стандартууд
- Бусад хууль, эрх зүйн актууд

2.5. Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд ахлах дотоод аудитор (Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч) Т.Мөнхзул хянан удирдаж, дотоод аудитор Г.Дорждэрэм нар гүйцэтгэв.

3.1 Байгууллагын сайн туршлага

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа – 2050”, шинэ сэргэлтийн бодлогод нийцүүлэн орон нутгийн хөгжлийн бодлого, зорилтуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажилласан байна. Тус сум төр, хувийн хэвшлийн үр дүнтэй түншлэл, салбар хоорондын уялдаа холбоо, гадаад харилцааны өгөөжтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэн ажилласны үр дүнд олон чухал ажлыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Эрчим хүчний станц барих ажлын талаар

Орон нутагт тулгамдсан хамгийн том асуудал дэд бүтцийн ажлын томоохон бүтээн байгуулалт 70 мбт-ын дулааны цахилгаан станц барих газар, үйлдвэрлэлийн бүс байгуулах 100 га газрыг шийдвэрлэсэн нь цаг хугацааны урсгалд аж үйлдвэржсэн шинэ Сүхбаатар сум сүндэрлэн босох эхлэлийг тавьсан байна.

Дэд бүтцийг хөгжүүлэх талаар

Мөн сум доторх авто зам, гэр хорооллын замуудыг шат дараалалтайгаар асфальтан зам болгож, явган хуний зам, гэрэлтүүлэг, гэрэлт гудамж, хүүхдийн тоглоомын талбай, хоккейн талбай, хөл бөмбөгийн талбай зэрэг хотын өнгө үзэмж, тохижилтыг нэмэгдүүлж иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл боломжийг сайжруулснаар иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлжээ.

Орон сууцны хангамжийг сайжруулах

Дахин төлөвлөлтийн хүрээнд Ган зам 7-р багт 336 айлын “Сүлд өргөө” орон сууц, Баянхаан 4-р багт 504 айлын “Сэлэнгэ мөрөн” хотхон зэрэг томоохон орон сууцны төслүүд хэрэгжиж, иргэдийн амьдрах орчныг сайжруулахад бодит ахиц гарсан байна.

Аялал жуулчлал, ногоон хөгжил

Сүхбаатар сум орчимд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд Сайхны хөтөлд дүүжин гүүр, зиплайн шүхрийн үйлчилгээ, морин аялал, хүүхэд залуусын тоглоомын талбай, худалдаа, хоолны газруудыг байгуулсан байна.

Мөн сумын Засаг даргын Тамгын газар, Мора Жи Эй групптэй хамтран “Мора агропарк” төслийг хэрэгжүүлж “Арвин агро Сэлэнгэ” хоршоо шинэ сортын үрийг япон технологиор эрүүл эко хүнсний нарийн ногоонууд болох Япон сортын “Шар тарвас”, “Черри лойл”-ыг амжилттай тариалж нутагшуулсан байна. Төслийн хүрээнд эрүүл эко хүнсний нарийн ногоонууд болох Япон сортын “Шар тарвас”, “Черри лооль”-ыг тариалж, хураан авсан ургацыг EMART сүлжээ их

дэлгүүрүүдтэй гэрээ байгуулан борлуулж эхэлсэн байна. Энэ нь орон нутгийн хүнсний ногооны тариалалтыг хөгжүүлж, чанартай хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэхэд хувь нэмэр оруулж байна.

Гэрэлт цогцолбор ба усан аялал

Орхон, Сэлэнгэ мөрнийг түшиглэн моторт завины үйлчилгээ, Гэрэлт цогцолборт худалдаа, үйлчилгээний байгууллагуудыг нэмэгдүүлж, иргэдийг тогтмол ажил, орлоготой болгох бодит санаачилга гарган хэрэгжүүлжээ.

2024 онд шинээр 60 ажлын байр бий болгосон байна.

Эдгээр нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих тод жишээ болж байна.

3.2 Засаглалын талаар

Сүхбаатар сумын ТТЗ нь Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль, Засгийн газрын тогтоол, хөтөлбөр, бодлого шийдвэр, албан даалгавар, Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн асуудлын талаарх төлөвлөсөн зорилтоо биелүүлж, тавьсан бодлого зорилтуудаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын удирдлагад ИТХ-ын даргаар М.Эрдэнэбат 2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, сумын Засаг дарга Т.Пүрэвсүрэн нь 2022 оны 03 дугаар сарын 29-ны өдрөөс өнөөдрийн хүртэл, Засаг даргын орлогч Ц.Пүрэвдорж 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөс өнөөдрийн хүртэл, Хонгорморьт 1 дүгээр багийн Засаг даргаар Б.Амгалан 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, Цагаан-Эрэг 2 дугаар багийн Засаг даргаар Ц.Алтанжин 2020 оны 11 дүгээр сарын 21-ны өдрөөс одоог хүртэл, Салхит 3 дугаар багийн Засаг даргаар С.Энхчимэг 2022 08 дугаар сарын 01-ны өдрөөс одоог хүртэл, Баян хан 4 дүгээр багийн Засаг даргаар Т. Мөнхтуяаг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс одоог хүртэл, Бор гүвээ 5 дугаар багийн Засаг даргаар Ш.Онон 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс одоог хүртэл, Орхон 6 дугаар багийн Засаг даргаар Б.Оюунаа 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс одоог хүртэл, Ганзам 7 дугаар багийн Засаг даргаар Б.Ганбат 2015 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс одоог хүртэл, Буур хээр 8 дугаар багийн Засаг даргаар Ч.Батбаяр 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс одоог хүртэл, сумын Засаг даргын Тамгын газрын дарга Э.Оюун-Эрдэнэ 2023 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс одоог хүртэл, Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Хунцэцэг 2024 оны 04 дугаар сарын 02-ний өдрөөс одоог хүртэл тус тус ажиллаж байна.

Сумын Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд

Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэхэд гол ажлуудыг шийдвэрлэсэн байна.

Төрийн захиргааны чиг үүргийн: үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах ажил арга хэмжээ хариуцсан ажилтан, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт хариуцсан ажилтан нарын ажлын байрны тодорхойлолт батлагдаагүй нь уг ажилтнуудын үүрэг тодорхойгүй, ажлын хариуцлага сул, удирдлагын төлөвлөгөө зохион байгуулалтгүй болох, засаглалын үйл ажиллагаанд хүндрэл үүсэх эрсдэлтэй.

Иймд төрийн захиргааны зарим мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр батлуулах, хүний нөөцийг чадавхжуулах, төсвийн зохистой зарцуулалтыг хэрэгжүүлэх зэрэг олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

3.3 Эрсдэлийн удирдлагын талаар

Эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэхэд эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийг тодорхойлоогүй, энэ талаарх нэгдсэн ойлголт байгаа ч эрсдэлийг урьдчилан тооцоолж бүртгэж үнэлэх арга хэмжээ зохион байгуулаагүй байна. Мөн санхүүгийн үйл ажиллагаа болон эрх бүхий албан тушаалтнаас гарах тушаал шийдвэрийн боловсруулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй нь эрсдэлийн удирдлагыг түвшин сул байгааг илэрхийлж байна.

Удирдлагын “ёс зүйтэй байдлыг дэмжин урамшуулах байдал”, ёс зүйгүй үйлдлийн эсрэг хандах хандлага, авах арга хэмжээ буруу, удирдлага шаардлага тавьсан ч үе шатны хяналтыг дутуу орхигдуулснаас хэрэгжилт нь хангалтгүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 2-р түвшинд байна

3.4 Дотоод хяналтын системийн талаар

Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон бусад баримт бичигт дотоод хяналтыг хэн хийх, хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй, дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй, хариуцсан ажилтангүй, зөвхөн байгууллагын өдөр тутмын болон санхүүгийн ажил гүйлгээг хянаж баталгаажуулах байдлаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа нь дотоод хяналтыг сулруулж байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын

шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй Аюул эрсдэлийг тодорхой хэмжээнд ярилцдаг боловч баримтжуулаагүй.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөхдөө учирч болох эрсдэлүүдийг авч бүртгэж түүнийг бууруулах талаар ярилцдаг боловч баримтжуулаагүй, үнэлгээ хийгдээгүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт-2120	
Асуудлын үндсэн шалтгаан: Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар холбогдох албан тушаалтанд сургалт зохион байгуулаагүй Эрсдэлийг зөвхөн шаардлагатай үед тодорхойлдог боловч бүрэн үнэлдэггүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: - Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах - Байгууллагын үнэ цэн буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана	
Шийдвэр: Байгууллагын албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгч, дотоод хяналтын нэгж хариуцсан ажиллагсдыг сургалтад үе шаттай хамруулж, чадавхжуулах -Гүйцэтгэх удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтан сонгон шалгаруулж авах -Байгууллагын эрсдэлийн түвшинг нэг шатлал ахиулан давтамжтай түвшинд шилжих зөвлөмж хүргүүлэх	

<u>Илэрсэн асуудал 2</u>	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээнд хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их

Бодит байдал:

Төсвийн төвлөрүүлэн захирагчид шууд харьяалагдах дотоод хяналт хариуцсан ажилтны орон тоог одоог хүртэл батлуулаагүй гүйцэтгэх чиг үүрэг тодорхойгүй, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулаагүйгээс дотоод хяналт сул байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4 дэх "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана."

Асуудлын үндсэн шалтгаан:

Дотоод хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаагүй, дотоод хяналтын чиглэлээр ажил зохион байгуулаагүй үндсэн үйл ажиллагаанд болон гүйцэтгэх удирдлагад тавих хяналтын тогтолцоог журамлаагүй, хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах хяналтуудыг орхигдуулсан.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Удирдлагын хяналт, гүйцэтгэх удирдлагын уялдаа холбоо хангагдаагүй хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхой бусад нэгжийн дотоод хяналын үр нөлөө сул үнэлгээ дүгнэлт хангалтгүй байна.

Шийдвэр:

Өөрийн эрхлэх хүрээний асуудал хариуцсан байгууллагууд болон гүйцэтгэх удирдлага, болон үндсэн үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын журмыг нэн яаралтай боловсруулах, дотоод хяналт хариуцсан ажилтантай болгож албан тушаалын тодорхойлолтод холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын заалтаар тусгаж өгөх. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх

<u>Илэрсэн асуудал 3</u>	Төрийн цахим хур системд ЗДТГ-ын эзэмшиж, ашиглах эрх олгосон 18 газар байгаагаас санхүүгийн тайлан бүртгэлд бүртгэгдсэн 5 байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал:	Сумын Засаг даргын захирамжаар ЗДТГ-т газар эзэмшүүлэх эрх олгосон нийт 18 газраас улсын бүртгэлээс э-дугаар олгосон 17 газар байгаагаас ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд 5 газар бүртгэлтэй бусад газрыг огт бүртгээгүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал

бүртгэнэ:,14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8 дахь “Төрийн өмчит хуулийн этгээд нь ...газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”

Асуудлын үндсэн шалтгаан: Засаг даргын дэргэдэх харьяа байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй, албан хаагчдын ажлын хариуцлага сул хөрөнгийн бүртгэлд тавих хяналт хангалтгүйгээс бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Санхүүгийн тайлан мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт сулаас шамшигдуулах өөрийн эзэмшлийн газрыг улсын бүртгэлд бүртгүүлээгүйгээс ЗДТГ-ын эзэмшилд байгаа газар дээр давхар олголт үүснээс шалтгаалан газрын маргаан үүсэх нөхцөл байдал бүрдсэн.

Шийдвэр: Сумын ЗДТГ-ын нэр дээрх үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй газрын үнэлгээг журмын дагуу үнэлж бүртгэлд авах, цаашид ашиглах шаардлагагүй бол хураан авч захирамжаар олгосон шийдвэрийг хүчингүй болгож цэгцлэх, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 4</u>	ЗДТГ-ын бусад авлага дансанд 2005 онд үүссэн гэх 6,623.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал:	ЗДТГ-ын бусад авлага дансанд 2005 онд үүссэн гэх байгууллагаас авах 4.106.0 мянган төгрөгийн, хувь хүнээс авах 2,517.6 мянган төгрөгийн нийт 6,623.7 мянган төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй, насжилт өндөртэй, хариуцагч нь тодорхойгүй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь ” Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”
Асуудлын үндсэн шалтгаан:	Авлага барагдуулах талаар санаачилга гарган ажиллаагүй, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Байгууллагын санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэгдэхгүй, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангагдахгүй байх.
Шийдвэр:	Цаашид ажлын хэсэг байгуулан он дамжсан 6,623.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 5</u>	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах Нийтийн эзэмшлийн байрны орцны засварт 250,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын 4.1 дэх дугаарт Нийтийн эзэмшлийн байрны орцны засварт 250,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг батлуулсан байна. Энэ нь байгууллагын урсгал болон хөрөнгийн зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой зардал юм.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 22 дугаар зүйлийн 22.1 дэх Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.1-4.3.8-д заалтууд,	
Асуудлын үндсэн шалтгаан: ОНХС-ийн болон сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг журмын дагуу төлөвлөөгүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Төсвийн хөрөнгө оруулалтын шалгуур хангахгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөө буурна.	
Шийдвэр: 2025 оны төсөв батлуулахдаа ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах төсөл арга хэмжээг тусгахгүй байх албан шаардлага хүргүүлэх	

<u>Илэрсэн асуудал 6</u>	2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 124,884.4 мянган төгрөгийн өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: 2-р сургууль камержуулалт хийх төсөл арга хэмжээ 44,884.4 мянган төгрөг, худаг барих 20,000.0 мянган төгрөг, дулааны шугам сайжруулах 20,000.0 мянган төгрөг, замын засвар, тэмдэг тэмдэглэгээ хийлгэх 20,000.0 мянган төгрөг, 1 дүгээр цэцэрлэгийн сангийн засвар 20,000.0 мянган төгрөг нийт 124,884.4 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөн батлуулсан бөгөөд үүнээс худаг барих 20,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээ нь огт хэрэгжээгүй бусад нь бүрэн хэрэгжсэн байна. Иргэдийн саналгүйгээр баталсан төсөл нь тухайн орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцэхгүй, үр ашиггүй зардал гарах эрсдэлийг бий болгосон байна. Энэ нь төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл юм.	

<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 60.3 дахь "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.6 дахь "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 5.3, 5.7, 5.8, 5.13 дахь заалтууд</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Иргэдийн саналгүй, эрэмбэлэгдээгүй төслийг төлөвлөсөн.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийг хөрөнгө үр ашиггүй зарцуулах, тухайн орон нутгийн бодит хэрэгцээг хангаж чадахгүй байх</p>
<p>Шийдвэр: 2025 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээнд орон нутгийн иргэдийн саналыг аваагүй төсөл, арга хэмжээ төлөвлөхгүй байх албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

<p><u>Илэрсэн асуудал 7</u></p>	<p>Сумын төсвийн хөрөнгөөр, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтад зураг, төсөв, үнийн судалгаа нь хийгдээгүй буюу өртөг нь тодорхойгүй 9 төсөл, арга хэмжээнд 2,120,000.0 мянган төгрөгийг тусгасан зөрчил байна</p>
<p><u>Асуудлын ангилал</u></p>	<p>Нөлөө их</p>
<p>Бодит байдал: ОНХО болон ОНХС-аас 2024 оны төсөвт шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээнээс 2,120,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан боловсруулаагүй төсвийг сумын ИТХ-ын 2023 оны 87 дугаар тогтоолоор батлуулсан байна. Үүнд:</p> <p>Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар:</p> <ul style="list-style-type: none"> • Явган хүний зам талбай, гарц, гэрэлтүүлгийн тохижилт 310,000.0 мянган төгрөг, • Хүүхдийн тоглоомын талбай байгуулах 160,000.0 мянган төгрөг, • Хайрган хучилттай сайжруулсан зам, зогсоол барих 200,000.0 мянган төгрөг, • Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх 600,000.0 мянган төгрөг, • Гэрэлт цогцолборт засвар хийх 150,000.0 мянган төгрөг • Гэрэлт гудамж тохижилт 100,000.0 мянган төгрөг <p>ОНХС-ын оруулалтаар</p> <ul style="list-style-type: none"> • Сүхбаатар сумын гудамж талбайд камержуулалт хийх 400,000.0 мянган төгрөг • Бохирын шугам татах шинэ суурьшлын бүс 70,000.0 мянган төгрөг • Дулааны шугам татах 130,000.0 мянган төгрөг байна. <p>Зураг, төсвийг урьдчилан хийгээгүйгээс төсөл, арга хэмжээний чанар, үр ашиг, хэрэгжих хугацаа хязгаарлагдах эрсдэлтэй.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: 13.3.3: "Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө</p>	

оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсаны дараа хийлгэснээс худалдан авах ажиллагаа оройтсон

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлөх, хяналт, шалгалтын явцад зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Шийдвэр: 2025 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний зураг, төсөв, үнийн судалгааг хийж төсөвт тусгуулсан байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв

<u>Илэрсэн асуудал 8</u>	Сумын Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-т 2014 оноос хойш үйлдвэрлэсэн toyota samru автомашин авахаар тендер зарласан боловч 2013 онд үйлдвэрлэсэн автомашин авсан байна.
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал: Сумын Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд тус байгууллагад 2014 оноос хойш үйлдвэрлэсэн toyota samru автомашин авахаар тендер зарласан байна. Тодруулбал: Тендерийн баримт бичигт тусгасан техникийн тодорхойлолтоор 2014 оноос хойш үйлдвэрлэсэн toyota samru автомашин худалдан авахаар заасан боловч, тээврийн хэрэгслийн гэрчилгээ дээр 2013 онд үйлдвэрлэсэн байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.”	
Асуудлын үндсэн шалтгаан: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар автомашин худалдан авахдаа тендерийн баримт бичигт тусгасан техникийн тодорхойлолтыг хангаагүй худалдан авалт хийсэн байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хууль зөрчих, дарга, удирдлага, худалдан авах комисс эрх мэдлээ урвуулан ашиглах, Төсвийг үр ашиггүй захиран зарцуулах	
Шийдвэр: Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар тээврийн хэрэгсэл худалдан авахдаа захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлага хангасан автомашин худалдан авах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	
<u>Илэрсэн асуудал 9</u>	Сумын Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжиж буй 5 төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэлийн баталгаа 37,530.1 мянган төгрөгийг тусгаагүй зөрчил

	байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
<p>Бодит байдал:</p> <p>Сумын Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжиж буй 5 төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэлийн баталгааны дүн гурван хувийг буюу 37,530.1 мянган төгрөгийг заагаагүй, “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргаагүй байна. “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын дагуу гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас багагүй үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлээгүй байна. Үүнд:</p> <p>ОНХС-ын хөрөнгө оруулалтаар: Сүхбаатар сумын гудамж талбайн камержуулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа 11,551.3 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн байрны орцны засварын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа 7,329.9 мянган төгрөг,</p> <p>Сумын хөрөнгө оруулалтаар: Хатуу хучилттай зам барих, гүүр засварлах төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа 12,053.9 мянган төгрөг, хайрган хучилттай сайжруулсан зам, зогсоол барих төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа 5,806.7 мянган төгрөг, гэрэлтүүлэг нэмэгдүүлэг төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа 17,788.2 мянган төгрөг, нийт 37,530.1 мянган төгрөг байна</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.4 дэх “Урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн баталгааны дүн”, 42.1 дэх “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана”, 42.2 дах “Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана”, “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 3.1 дэх “Хуулийн 42.1-д зааснаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас багагүй үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлнэ”</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <p>ТБОНӨХБАҮХА тухай хуулийн болон Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын холбогдох заалтыг мөрдөөгүй байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <p>Гүйцэтгэгч тал гэрээг биелүүлэхгүй байх эсвэл гүйцэтгэл хангалтгүй байхад баталгааны хөрөнгийг ашиглах боломжгүй, байгууллага хохирох эрсдэлтэй.</p>	
<p>Шийдвэр:</p> <p>ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.4 болон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 3.1 дэх заалтыг мөрдөж, гүйцэтгэлийн баталгаа гаргаж байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>	

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллага өөрийн зорилгодоо хүрэхийн тулд ажил хэргээ арвигч хямгач, үр дүнтэй эрхлэн явуулахад сайн зохион байгуулагдсан хяналтын тогтолцоо хэрэгтэй гэдгийг удирдлага ойлгон түүнийг хэрэглэх механизмаа бүрдүүлэх, шийдвэр гаргалтад түүний үр нөлөөг ашиглаж чаддаг байх нь чухал.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 77.8 хувь нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР



Г.ДОРЖДЭРЭМ

ТАЙЛАН ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ АХЛАХ ДОТООД
АУДИТОР, СХШУБ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:
СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ ДАРГА



Т.ПҮРЭВСҮРЭН

ТӨСВИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д. ХУНЦЭЦЭГ

Дотоод аудитын ажлын хэсэг

- Дотоод аудитыг явуулахдаа удирдамжийн хүрээнд ажиллах;
- Дотоод аудитад хамрагдаж буй байгууллагад хүндрэл учруулахгүй байх;
- Дотоод аудитын ажлын явцад хамрагдаж буй байгууллага, газрын талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах;
- Дотоод аудитын тайлангийн төслийг тухайн байгууллагын холбогдох албан тушаалтанд танилцуулах, шаардлагатай гэж үзвэл залруулга хийх;
- Дотоод аудитын дүрмийг баримтлан, бие даасан хараат бусаар гүйцэтгэх;
- Дотоод аудитын хорооноос гарсан шийдвэр, зөвлөмжийг холбогдох байгууллага, газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

9. Дотоод аудитын дүнг тайлагнах

10. 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дотоод аудитаар илэрсэн асуудлуудад өгсөн шийдвэрийн биелэлтийн тайланг албан тоотын хамт ирүүлэх.

Хянасан:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

Т.Одсүрэн

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Боловсруулсан:

Дотоод аудитор:

Г.Дорждэрэм

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр